



МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ ЖУРАМ



Бүртгэлийн дугаар -	Мөрдөж эхлэх огноо: 2023/08/03	Хувилбарын дугаар – 1.0	Хуудасны тоо - 11
---------------------	-----------------------------------	----------------------------	-------------------

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2023 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн
23/24 тоот тогтоолын 4 дүгээр хавсралт

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ ЖУРАМ

Баримтын төрөл:	Журам
Нууцын зэрэглэлтэй эсэх:	Олон нийтэд хүргээжтэй
Зохицуулах үйл ажиллагаа:	Хувьцаа эзэмшигч, Хөрөнгө оруулагч, олон нийтэд компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг хүргэх
Хариуцах нэгж/ ажилтан:	Эрсдэл, хянан нийцүүлэлтийн газар
Тус хувь хүртэх нэгж/ танилцах ажилтан:	Бүх нэгж/ Бүх ажилнууд



АГУУЛГА

Мэдээллийн ил тод байдлын тухай журам
Хувилбар 1.0

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

ХОЁР. ХУГАЦААТ ТАЙЛАНГ НИЙТЭД МЭДЭЭЛЭХ

ГУРАВ. ТУХАЙ БҮР НИЙТЭД МЭДЭЭЛЭХ МЭДЭЭЛЭЛ

ДӨРӨВ. НУУЦ МЭДЭЭЛЭЛ

ТАВ. ХАРИУЦЛАГА

ЗУРГАА. БУСАД

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү Мэдээллийн ил тод байдлын тухай журам (цаашид “Журам”)-аар “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч болон олон нийтэд компанийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл болон хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тогтмол хүргэх, мэдээллийн ил тод байдлыг хангах, мэдээллийн төрөл, хэлбэр давтамж, түүнийг хэрэгжүүлэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.2. Компани нь холбогдох хууль тогтоомжийн дагуу Компанийн нууцад хамаарахаас бусад мэдээлэл нээлттэй, ил тод, бодитой, үнэн зөв, агуулгын хувьд хоёрдмол утгагүй бүрэн гүйцэт мэдээлэх, мэдээллийг нийтэд хүргэх үйл ажиллагаа шуурхай байх зарчмыг баримтална.
- 1.3. Компани нь аливаа мэдээллийг Монгол хэл дээр бичгэн болон тоон хэлбэрээр үйлдэх ба өөрийн цахим хуудас болон “Монголын хөрөнгийн бирж” ХК (цаашид “Бирж”)-ийн цахим хуудсаар дамжуулан хүргэнэ. Шаардлагатай гэж үзвэл нэмэлтээр гадаад хэлээр мэдээллийг хүргэж болно.
- 1.4. Компанийн цахим хуудас болон Биржийн цахим хуудаст хандаж мэдээллийг нээлттэй болгох ажиллагааг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн Нарийн бичгийн дарга, Хууль, хянан нийцүүлэлт хариуцсан мэргэжилтэн нар Компанийн Маркетингийн албатай хамтран гүйцэтгэнэ.
- 1.5. Компанийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга болон Хууль хянан нийцүүлэлт хариуцсан мэргэжилтэн нар Биржийн цахим хуудаст хандаж мэдээ байршуулахад Биржээс олгосон нэвтрэх нэр, нууц үт ашиглах бөгөөд цахим хуудаст хандах нэвтрэх нэр, нууц үгийг зориулалтын бусаар ашиглах, бусдад дамжуулах, санаатай болон санамсаргүй байдлаар бусдад олгохыг хориглоно.
- 1.6. Энэхүү журмын 1.5-д заасан этгээд өөрчлөгдсөнөөс хойш ажлын 3 хоногийн дотор Биржид мэдэгдэнэ.
- 1.7. Энэхүү журамд заасан дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:
 - 1.7.1. “Мэдээллийг нийтэд хүргэх” гэж Компани нь холбогдох хууль тогтоомж болон энэ журамд заасан мэдээллийг өөрийн болон Биржийн цахим хуудсаар дамжуулан нийтэд хүргэхийг;
 - 1.7.2. “Тухай бүр мэдээлэх” гэж энэ журамд заасан тухай бүр мэдээлэх мэдээллийг тухайн үйл явдал болсон даруй нийтэд мэдээлэхийг;
 - 1.7.3. “Дотоод мэдээлэл эзэмшигч” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 77 дугар зүйлийн 77.1-д заасан этгээдийг;
 - 1.7.4. “Эрх бүхий албан тушаалтан” гэж Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1-д заасан этгээдийг;

- 1.7.5. “Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.29-д заасан этгээдийг;
- 1.7.6. “Хугацаат тайлан” гэж хувьцаа эзэмшигчдийн хурал болон хөрөнгө оруулагч, олон нийтэд мэдээлэл хүргэх зорилгоор Компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг агуулсан тайланг.

ХОЁР. ХУГАЦААТ ТАЙЛАНГ НИЙТЭД МЭДЭЭЛЭХ

- 2.1. Компанийн Хугацаат тайлан нь эхний хагас жилийн болон жилийн санхүү, үйл ажиллагааны тайлан гэсэн хэлбэртэй байна. Жилийн Хугацаат тайланг тухайн жилийн 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор, эхний хагас жилийн Хугацаат тайланг дараа сарын 20-ны дотор Хороо болон Биржид хүргүүлж, Биржийн болон өөрийн цахим хуудаст нийтэлнэ.
- 2.2. Компани нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /IFRS/-д нийцүүлэн үнэн зөв гаргаж жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 2 дугаар сарын 10-ны өдрийн дотор, эхний хагас жилийн санхүүгийн тайланг дараа сарын 20-ны өдрийн дотор Хороо болон Биржид хүргүүлж, Биржийн болон өөрийн цахим хуудаст нийтэлнэ.
- 2.3. Компани нь аудитын байгууллагаар баталгаажуулсан аудитлагдсан санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 01-ний өдрийн дотор, хагас жилийн санхүүгийн тайланг Хороо болон Биржид хүргүүлж, Биржийн болон өөрийн цахим хуудаст нийтэлнэ.
- 2.4. Санхүү, үйл ажиллагааны тайлангийн мэдээллийг Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо”), Биржийн үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил, тод байдлыг зохицуулахаар баталсан холбогдох журмуудад заасны дагуу бэлтгэж, заасан хугацаанд Хороо болон Биржид хүргүүлнэ.
- 2.5. Компани нь жилийн Хугацаат тайланд дараах мэдээллийг тусгана:

№	Мэдээллийн ерөнхий агуулга	Тайлбар
1	Тайлант хугацааны санхүүгийн мэдээлэл	<ul style="list-style-type: none">• үнэт цаас гаргагчийн жилийн санхүүгийн тайлан тэнцэл (Санхүүгийн байдлын үзүүлэлт, Орлогын тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан), тодруулга;• аудитын үйлчилгээ үзүүлсэн компани нь санхүүгийн тайландаа орсон мэдээлэл нь үнэн зөв, олон улсын стандартын дагуу тайлагнаасныг баталж, үйлчилгээ үзүүлсэн этгээдтэй сонирхлын зөрчил үүсгээгүй, хараат бусаар ажилласан талаарх баталгаат захидал;• үнэт цаас гаргагчийн санхүүгийн жилд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл.
1.1	Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт	-

1.2	Аудитын тодорхойлох захидал	Тодорхойлох захильтыг Хорооны холбогдох зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулна.
2	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл	<ul style="list-style-type: none"> • Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/; • Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт; • Компанийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд Компанийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл; • Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл; • Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл.
3	Тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл	Хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээллийг тусгана
4	Цалин урамшууллын мэдээлэл	Санхүүгийн жилд төлөөлөн удирдах зөвлөлийн хараат болон хараат бус гишүүд, гүйцэтгэх удирдлагад олгосон цалин урамшуулал, шагнал, тэдгээрийн эзэмшдэг опцион болон хувьцааны тоо ширхэг, үнэт цаас гаргагчаас баримталдаг нөхөн олговор, урамшуулал, шагналын талаарх баримталдаг бодлого.
5	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл	<ul style="list-style-type: none"> • Компанийн ТУЗ-ийн гишүүд, болон Компанийн удирдлага бүтэц, бүрэлдэхүүний мэдээлэл; • Хэрэв удирдлагын бүтэц, бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт орсон бол энэ талаарх мэдээлэл; • Компанийн ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүтэц, чиг үүрэг, хариуцлага; • Компанийн ТУЗ, түүний дэргэдэх хороодын үйл ажиллагааны тайлан; • Ёс зүйн кодекс, эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийн талаарх мэдээлэл; • Компанийн ТУЗ болон түүний дэргэдэх хороодын ажлын тайлан, хэрэв хуралдаж амжсан бол тайланг хэлэлцсэн хувьцаа эзэмшигчдийн хурлын дүгнэлт; • Компанийн санхүү болон үйл ажиллагааны тайланг дүгнэсэн хэлэлцсэн ТУЗ-ийн дүгнэлт; • Дотоод аудитын ажлын тайланг хэлэлцсэн ТУЗ-ийн дүгнэлт, мэдээлэл;

		<ul style="list-style-type: none"> Компанийн засаглалыг үнэлсэн үнэлгээний тайланг Компанийн засаглалын кодексын аргачлалын дагуу тайлагнана.
6	Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл	<p>Тайлант хугацаанд бий болсон, эсхүл бий болж болзошгүйд тооцож, тухайн эрсдэлийг удирдах чиглэлээр авч хэрэгжүүлсэн эрсдэлийг удирдах стратегийн талаарх мэдээлэл, эрсдэлийг тооцдог арга аргачлал, эрсдэлийг удирдах стратегийн талаарх мэдээлэл.</p>
7	Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/	<ul style="list-style-type: none"> Компанийн тайлант жил дэх эцсийн өмчлөгч болон нөлөө бүхий, хяналтын багц эзэмшигч гадаад дотоодын иргэн, аж ахуйн нэгжийн нэрс, хувьцааны тоо ширхэг, төвлөрлийн мэдээлэл; Компанийн хувьцааг эзэмшидэг охин, хараат компанийн мэдээлэл, Тайлант хугацаанд Монгол Улсын Компанийн тухай хуульд заасны дагуу шаардах эрхээ хэрэгжүүлэн хувьцаа худалдсан хувьцаа эзэмшигчийн тоо, үнийн дүнгийн мэдээлэл;
8	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл	-
9	Ногдол ашгийн мэдээлэл	Компанийн ногдол ашгийн бодлого, тухайн жилд хуваарилсан ногдол ашгийн хэмжээ, тараах хэлбэр, ногдол ашиг хуваарилахгүй тохиолдолд энэ талаарх үндэслэл, өмнөх жилд ногдол ашиг хуваарилсан тохиолдолд түүний тараалтын тайлан, мэдээлэл.
10	Компанийн тайлант хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын мэдээлэл	-
11	Үнэт цаас гаргагчийн бүтэц /толгой, охин, хараат, зэргэлдээ компаниуд тэдгээрийн хувь эзэмшлийн талаар/, холбоотой талуудын санхүүгийн гүйлгээний талаарх мэдээлэл.	Хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээллийг тусгана
12	Үнэт цаас гаргагч нь Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3, 61 дүгээр зүйлийн 61.1.3, 61.1.4-д заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд авч урьдчилан сэргийлж, энэхүү нөхцөл байдал үүссэн тохиолдолд авч	Энэхүү нөхцөл байдал үүссэн тохиолдолд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай тусгана

	хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээлэл.	
13	Тайлант хугацаанд эргүүлэн худалдан авсан халаасны хувьцааны тоо, ширхэг, ажилтнуудад хувьцаа эзэмшигүүлэх хөтөлбөр хэрэгжүүлсэн, үнэт цаасаар дамжуулан урамшуулалт олгосон талаарх мэдээлэл.	Тайлант хугацаанд энэхүү нөхцөл байдал үүссэн бол энэ талаар тусгана.
14	Компани шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл.	-

- 2.6. Компани нь эхний хагас жилийн Хугацаат тайландаа энэхүү журмын 2.5-д заасан мэдээллээс Хороо, Биржийн үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил, тод байдлыг зохицуулахаар баталсан холбогдох журмуудад заасан мэдээллийг тусгана.
- 2.7. Компани нь эхний хагас жилийн Хугацаат тайланг Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороогоор хэлэлцэж, дүгнэлт гаргасныг үндэслэн Хороо, Биржид хүргүүлж, олон нийтэд мэдээлнэ.
- 2.8. Компани шаардлагатай гэж үзвэл энэхүү журмын 2.1-т заасан тайлангаас гадна тухайн улирлын үйл ажиллагааны тайланг нэмэлтээр гаргаж болно.
- 2.9. Компани нь Хугацаат тайлан болон энэхүү журмын 2.8-д заасан тайланг олон нийтэд хүргэхдээ Компанийн өнгө төрхөд нийцүүлэн, олон нийтэд ойлгомжтой, хялбарчилсан байдал (сэтгүүл, ном, танилцуулга гэх мэт)-аар гаргаж болно.

ГУРАВ. ТУХАЙ БҮР НИЙТЭД МЭДЭЭЛЭХ МЭДЭЭЛЭЛ

- 3.1. Компанийн ТУЗ болон Гүйцэтгэх удирдлага нь хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдад Компанийн бизнесийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, түүний эдийн засгийн үзүүлэлтүүд, өмч хөрөнгийн болон удирдлага зохион байгуулалтын бүтэцтэй холбоотой өөрчлөлт орсон мэдээллийг тухайн өдрөөс хойш ажлын 1 хоногт багтаан олон нийтэд тухай бүр мэдээлнэ.
- 3.2. Компани нь тухай бүр мэдээлэх мэдээллийг Хорооны холбогдох журамд заасан байдлаар бэлтгэн Хороонд хүргүүлж, Биржийн цахим хуудас болон өөрийн цахим хуудсанд нийтлэх байдлаар олон нийтэд мэдээлнэ.
- 3.3. Компанийн тухай бүр мэдээлэх мэдээлэл гэдэгт дор дурдсан мэдээллүүд хамаарна:
- 3.3.1. Компанийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, бизнест шууд нөлөө үзүүлэхүйц гэрээ, хэлцэл байгуулах, нэмэлт өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, дуусгавар болгох, татгалзах, гэрээний хугацаа дууссантай холбоотой мэдээлэл: Тус мэдээлэлд гэрээг байгуулсан огноо, гэрээний нөхцөл, гэрээнд оролцогч талуудын ерөнхий эрх, үүрэг, гэрээний нэг талд түүний охин хараат компани оролцсон эсэх талаарх мэдээлэл;

- 3.3.2. Шүүх, прокурор, төрийн эрх бүхий байгууллагаас Компанийн эрх бүхий албан тушаалтан, түүний хараат, охин компанийг хариуцагчаар татаж, захиргааны болон эрүүгийн хэрэг үүсгэсэн, шүүхээс дампуурлын тухай хууль тогтоомжийн дагуу эрх хүлээн авагч томилогдсон талаарх мэдээлэл;
- 3.3.3. Компанийн нийт активын 25 хувь ба түүнээс дээш хэмжээтэй тэнцэх үл хөдлөх хөрөнгийг бусад шилжүүлэх, барьцаалсан эсхүл бусад компанийн хяналтын багц худалдан авсан талаарх мэдээлэл, холбогдох гэрээ, хэлцэл;
- 3.3.4. Компанийн санхүүгийн байдлын гадуурх бүртгэлтэй холбоотой санхүүгийн болон санхүүгийн бус эрх үүрэг бий болгосон гэрээ, хэлцэл, гүйлгээтэй холбоотой мэдээллийг мэдээлэх бөгөөд мэдээлэлд гэрээ, хэлцлийн хугацаа, үнийн дүн, төлбөрийн нөхцөл, гүйлгээний товч утга, богино болон урт хугацаат түрээсийн гэрээнээс бий болсон эрх үүрэг, төлбөр түргэн гүйцэтгэх чадвартай холбоотой мэдээлэл;
- 3.3.5. Компанийн эрх бүхий этгээдээс СТОУС-ын дагуу Компанийн хөрөнгийн үнэ цэн буурсан гэж үзэн дахин үнэлгээ хийхээр шийдвэрлэсэн тохиолдолд холбогдох шийдвэр, шийдвэрийг гаргах болсон нөхцөл, шаардлага, үнэ цэн нь буурсан хөрөнгө болон хөрөнгийн үнэ цэнгийн бууралтын хэмжээ эсхүл хязгаарын тооцоолол;
- 3.3.6. Биржийн бүртгэлийн шалгуурыг хангахгүй болсонтой холбогдуулан бүртгэлийн ангилал бууруулах, эсхүл бүртгэлээс хасагдах мэдэгдэл хүлээн авсан тухай мэдээлэл. Хэрэв Компани нь Биржийн бүртгэлд үлдэх хүсэлт гаргасан бол уг хүсэлт хүргүүлсэн огноо болон дээрх мэдэгдлийн дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээ, бүртгэлтэй хугацаанд биелүүлсэн болон хангаж чадаагүй гэрээгээр хүлээсэн үүргийн талаарх мэдээлэл;
- 3.3.7. Компанийн тайланд аудит хийж буй хараат бус нягтлан бодогч ажлаас чөлөөлөгдсөн, халагдсан зэрэг шалтгаанаар өөрчлөгдсөн тохиолдолд энэ талаар мэдэгдэх бөгөөд нягтлан бодогчоос үнэт цаас гаргагчийн дээрх мэдээлэлтэй санал нийлж буй эсэх талаар мэдэгдлийг хавсаргана, эсхүл шинэ хараат бус нягтлан бодогч ажилд орсон бол ажилд томилсон шийдвэр, шинэ нягтлан бодогчийн Компанийн санхүүгийн тайлантай холбоотой гаргасан санал, дүгнэлт, зөвлөгөө;
- 3.3.8. Компанийн эрх бүхий этгээдээс компанийн өмнөх жилүүдийн санхүүгийн тайланд алдаа гарсан гэж үзсэн бол алдаатай санхүүгийн тайлангууд, алдаа гарсан гэж үзэх үндэслэл, нөхцөл, компанийн аудитын хороо, эсхүл эрх бүхий албан тушаалтан энэ талаар хараат бус нягтлан бодогчтой хэлэлцсэн эсэх талаар мэдээлэл, хараат бус нягтлан бодогчоос үнэт цаас гаргагчид санхүүгийн тайлангийн алдаатай байдлын талаар мэдэгдсэн бол нягтлан бодогчоос өгсөн мэдэгдлийн огноо, товч агуулгын талаарх мэдээлэл;
- 3.3.9. Компанийн хяналтын багцыг бусад этгээдэд шилжүүлэхтэй холбоотой мэдээлэл: Компанийн хяналтын хувьцааг худалдах болон шилжүүлэхээр хийгдсэн хэлцлийн хугацаа, товч танилцуулга, зорилго, төлбөр төлөх хэлбэр, төлбөрийн зарцуулалт, худалдан авагчийн товч танилцуулга, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт, өмнөх хувьцаа эзэмшигчдийн хувь хэмжээний бууралтын талаарх мэдээлэл;

- 3.3.10. Компанийн эрх бүхий албан тушаалтан, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдийг томилж, чөлөөлөхтэй холбоотой мэдээлэл, хувьцаа эзэмшигчдийн хурлаар төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдийг томилж, огцруулж, нөхөн томилох, эсвэл татгалзсан хурлын тэмдэглэл, шийдвэрийн агуулга, огноо, төлөөлөн удирдах зөвлөлөөс гүйцэтгэх удирдлагыг томилж, чөлөөлсөн талаарх мэдээлэл;
 - 3.3.11. Компанийн дүрэмд орсон өөрчлөлт: Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж баталсан дүрмийн өөрчлөлтийг Хороо, төрийн холбогдох байгууллагад бүртгүүлсэн огноо, дугаар, хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, эцэслэсэн дүрэм;
 - 3.3.12. Компанийн гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан нь үүрэгт ажлаас чөлөөлөгдсөн, гарсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд тухайн ажиллаж байсан компанийн хувьцааг бирж болон биржийн бус зах зээл дээр худалдах, худалдан авахыг хориглосон арга хэмжээ болон үүнтэй холбогдуулан компанийн төлөөлөн удирдах зөвлөлөөс гарсан шийдвэр, арга хэмжээний талаарх мэдээлэл;
 - 3.3.13. Компанийн ёс зүйн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, зарим хэсгийг түр түдгэлзүүлсэн талаарх мэдээлэл;
 - 3.3.14. Компани үйл ажиллагаанд шинэ техник, технологи нэвтрүүлэх, хувьцааны ханшид нөлөөлөхүйц шинэ бүтээгдэхүүн зах зээлд танилцуулсан, үндсэн болон шинэ бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөл, патент, үйл ажиллагаа явуулах болон барааны тэмдэг эзэмших эрх хүчингүй болсон эсхүл цуцлагдсан талаарх мэдээлэл;
 - 3.3.15. Компанийн оноосон нэр, үндсэн захиргаа, оршин байх хаяг байршил өөрчлөгдсөн бол энэ талаар, салбар, төлөөлөгчийн газар байгуулах, эсхүл татан буулгах талаарх мэдээлэл;
 - 3.3.16. Компанийн үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн, үйл ажиллагаа түр болон удаан хугацаагаар эсхүл бүхэлдээ зогссон тохиолдолд энэ талаарх мэдээлэл;
 - 3.3.17. Компани төлбөрийн чадваргүй болох, үнэт цаас гаргагчийг татан буулгах чиглэлээр гаргасан шийдвэр.
- 3.4. Компани нь энэхүү Журмын 3.4-т заасан мэдээллээс гадна дараах мэдээллийг Биржид энэхүү Журамд заасны дагуу мэдээлнэ:
 - 3.4.1. Компанийн Гүйцэтгэх удирдлага, ТУЗ-өөс гаргасан үнэт цаасны үнэ ханшид болон Компанийн үйл ажиллагаанд нөлөөлөх шийдвэрүүд;
 - 3.4.2. Нийт ажилтнуудын 15 болон түүнээс дээш хувьд өөрчлөлт орох буюу чөлөөлөгдөх, шилжих, шинээр ажилд орсон талаарх мэдээлэл;
 - 3.4.3. Компанийн Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний холбогдох этгээд, тэдгээрийн хувьцаа эзэмшилд гарсан өөрчлөлт;
 - 3.4.4. Компанийн Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний холбогдох этгээд, тэдгээрийн бусад Компанид эзэмшиж байгаа хувьцаанд гарсан өөрчлөлт;
 - 3.4.5. Дотоод мэдээлэл эзэмшигч, түүнд орсон өөрчлөлт;
 - 3.4.6. Компанийн үйл ажиллагаа явуулж салбарт эзлэх байр суурийн талаарх мэдээлэлд түүнд орсон өөрчлөлт;
 - 3.4.7. Компанийн охин, хараат компаниудын үйл ажиллагаатай холбоотой аливаа тусгай зөвшөөрөл эзэмших болсон эсхүл хүчингүй болгосон, барьцаалсан, аливаа хэлбэрээр бусад шилжүүлсэн тухай мэдээлэл;

- 3.4.8. Компани нь борлуулалтын орлогын 20 ба түүнээс дээш хувьд нөлөөлөх үйл ажиллагаатай холбогдох аливаа тусгай зөвшөөрөл, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай байгуулсан гэрээ хэлцлийг цуцлах, дуусгавар болгосон талаарх мэдээлэл;
- 3.4.9. Компани нь өөрийн үнэт цаасаа эргүүлэн худалдан авах, худалдан авсан хувьцаагаа бусдад шилжүүлэх, эргэлтэд гаргах тухай шийдвэр: Шийдвэрт үнэт цаасыг худалдан авах (худалдах) зорилго, авах (эргэлтэд гаргах) хувьцааны тоо, үнэ, нийт хувьцаанд эзлэх хувь, төлбөр хийх хугацааны талаар тусгана;
- 3.4.10. Компани нь их хэмжээний хэлцэл болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдсэн тохиолдолд тухайн мэдээлэл;
- 3.4.11. Дараа жилийн үйл ажиллагааны зорилт, төлөвлөгөө, төсвийн талаарх мэдээлэл;
- 3.4.12. Компанийн үйл ажиллагааны зарим хэсгийг охин, хараат компани болон бусад этгээдэд шилжүүлэх, эсхүл хязгаарлах болсон;
- 3.4.13. Компанийн үндсэн болон шинэ бүтээгдэхүүнд зориулан тусгай зөвшөөрөл, патент, үйл ажиллагаа явуулах эрх, барааны тэмдэг эзэмших болон цуцлагдсан;
- 3.4.14. Компанийг нэгдэх, нийлэх, хуваах, тусгаарлах зэргээр өөрчлөн байгуулах болон татан буулгах шийдвэр;
- 3.4.15. Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим хуудас, цахим сүлжээгээр тархсан худал, цуурхал, ташаа мэдээллийн талаар Биржийн цахим хуудас болон өөрийн цахим хуудсаар дамжуулан мэдэгдэл, мэдээлэл, тайлбар;
- 3.4.16. Хороо болон Биржийн холбогдох журамд заасан бусад мэдээлэл.

ДӨРӨВ. НУУЦ МЭДЭЭЛЭЛ

- 4.1. Компани нь өөрийн нууцтай холбоотой журамд заасан болон Монгол Улсын Байгууллагын нууцын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд заасан нууцад хамаарах аливаа мэдээллийг хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд задруулахгүй, задруулахаас сэргийлж ажиллана.

ТАВ. МЭДЭЭЛЛИЙГ ХАДГАЛАХ, БУСАД МЭДЭЭЛЭЛ

- 5.1. Компани нь нийтэд мэдээлсэн Хугацаа тайлагнал болон Тухай бүр мэдээлэх мэдээллийг өөрийн цахим хуудсанд нийтэлсэн цагаас хойш 5 жилийн хугацаанд хадгалж, хувьцаа эзэмшигч болон бусад сонирхогч этгээд танилцах боломжийг олгоно.
- 5.2. Компани нь өөрийн цахим хуудсанд энэхүү Журамд зааснаас гадна дор дурдсан баримт бичгийг байршуулж, хувьцаа эзэмшигч болон бусад сонирхогч этгээд танилцах боломжийг олгоно:
 - 5.2.1. Компанийн дүрэм;
 - 5.2.2. Компанийн ТҮЗ-ийн гишүүдийн товч мэдээлэл;
 - 5.2.3. Компанийн засаглалын кодекст заасан Компани үйл ажиллагаанд мөрдөгдөж буй журмууд;
 - 5.2.4. Компанийн түүх, танилцуулга, үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл;
 - 5.2.5. Компанийн эрхэлж буй үйлчилгээний мэдээлэл, түүний нөхцөлүүд;
 - 5.2.6. Компанийн хувьцааны талаарх мэдээлэл;
 - 5.2.7. Компаниас шаардлагатай гэж үзсэн мэдээлэл;

5.2.8. Хууль тогтоомжид заасан бусад мэдээлэл.

5.3. Компанийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга болон Хууль хянан нийцүүлэлт хариуцсан мэргэжилтэн нар энэхүү Журмын 6.2-т заасан мэдээлэлд өөрчлөлт орсон тухай бүрд шинэчлэх ажлыг зохион байгуулна.

ЗУРГАА. ХАРИУЦЛАГА

- 6.1. Компанийн мэдээллийг холбогдох хууль, журамд заасан хугацаанд үнэн зөв, бүрэн гүйцэт мэдээлж байгаа эсэхэд Компанийн эрх бүхий албан тушаалтнууд болон Компанийн Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо хяналт тавин ажиллана.
- 6.2. Компанийн Дотоод мэдээлэл эзэмшигч нь энэхүү Журамд заасны дагуу нийтэд мэдээлэхээс өмнө уг мэдээллийг санамсаргүй болон санаатайгаар мэдээлэх, дамжуулах, ашиглах, бусад олж авах нөхцөлийг бүрдүүлэхийг хориглоно.
- 6.3. Компани нь энэхүү Журмыг зөрчсөн тохиолдолд зөрчил гаргасан этгээдэд Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх талаар эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлнэ.
- 6.4. Компани нь тухайн зөрчлийн шинж байдлыг харгалzan зөрчил гаргасан этгээдэд Компанийн хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд заасны дагуу сахилгын арга хэмжээ хүлээлгэж болно.

ДОЛОО. БУСАД

- 7.1. Энэхүү Журам нь Компанийн ТУЗ баталсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- 7.2. Энэхүү Журмыг холбогдох хууль тогтоомжтой нийцүүлэн шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах эрх гагцхүү Компанийн ТУЗ-д хадгалагдана.
- 7.3. Энэхүү Журмын хэрэгжилтэд Компанийн ТУЗ хяналт тавьж ажиллана.
- 7.4. Энэхүү Журмаар зохицуулаагүй бусад харилцааг холбогдох хууль тогтоомж болон Компанийн дүрэм, журамд заасны дагуу зохицуулна.
- 7.5. Энэхүү Журамд иш татсан хууль тогтоомжийн аливаа зохицуулалтад өөрчлөлт орсноор холбогдох зүйл, хэсэг, заалтууд өөрчлөгдсөн нь энэхүү Журмын тухайн зохицуулалт хүчингүй болох үндэслэл болохгүй.

-ЛЭНДМН ББСБ ХК-